



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/104

Мандалговь

Г Тусламж үзүүлэх тухай Т

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/г/, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 1 дүгээр багийн өндөр настан Ичинхорол овогтой Мягмаржавын биеийн эрүүл мэнд, амьдралын хүнд байдал, аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдлийг харгалзан үзэж нэг удаагийн тусламжийг үзүүлсүгэй.

Хоёр. Тусламжид шаардагдах 300000 /Гурван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАТ-ЭРДЭНЭ

0200316